

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

| ЗОРИГЖУУЛНА

| МЭДЭЛЖҮҮЛНЭ

Пүрэв, 2020.01.16, №02 (131)

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН,
УЛС ТӨРИЙН НАМААС ХАРААТ БУС, ДОЛОО ХОНОГ ТУТМЫН ГЛОБАЛ СОНИН

www.jargaldefacto.com

WEEKLY



ДеФакто **НИЙТЛЭЛ**
№511

Д.Жаргалсайхан
Эдийн засагч, нийтлэлч

ХҮҮХДИЙН СҮҮ БА ҮНДЭСТНИЙ ИРЭЭДҮЙ



БОЛОВСРОЛ

Б.Насанбаяр
Ph.D /Боловсрол судлал/

ЛИБЕРАЛ — БОЛОВСРОЛ —

IV НҮҮРТ

ДеФакто **ТОЙМ**

➤ ТЭТГЭВРИЙН ЗЭЭЛИЙГ
ТЭГЛЭСНЭЭР
ЭХНИЙ ЭЭЛЖИНД
БАНКУУД ХОЖИЖ БАЙНА

➤ ЗАРИМ ШҮҮГЧДИЙГ
ТОМИЛОО

➤ АИ-92 ШАТАХУУНЫ
ҮНИЙГ ТОГТВОРТОЙ
БАЙЛГАХААР
ЭРСДЛИЙН САН
БАЙГУУЛНА

VI НҮҮРТ

ХҮҮХДИЙН СҮҮ БА ҮНДЭСТНИЙ ИРЭЭДҮЙ



Хүний аз жаргал, амжилт нь хүүхэд байхдаа шаардлагатай шим тэжээлээ авсан эсэхээс ихээхэн хамаардаг ажээ. Хэрэв багадаа тэр хэрэгцээт шим тэжээлээ аваагүй бол том болоод олох орлогод нь хүртэл нөлөөлдөг гэнэ. Иод, төмөр, кальци гэх мэт бичил тэжээлийн элементүүд хүртэл эдийн засгийн хөгжилтэй холбогддог. Энэ дүгнэлтийг 2019 оны Нобелийн шагнал хүртсэн MIT сургуулийн эдийн засагчид Абхижит Банерже, Эстер Дуфло нар хийжээ. Тэд олон орны ядуу иргэдийн асуудал, ядуурлыг шийдэх төр засгийн оролдлогыг судалсан дээрх дүгнэлтээ 2010 онд хэвлүүлсэн "Poor eonomics" (Ядуу эдийн засаг) номондоо оруулжээ.

Ер нь нийгмийн тэгш бус байдал, ядуурлын эх сурвалж нь хүүхэд байхаас, зарим тохиолдолд бүр төрөхөөс өмнө бий болдог. Тийм ч учраас олон орны бодлого боловсруулагчид бага насны, тэр дундаа сургуулийн насны хүүхдүүдэд зориулж тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх болжээ. Жишээлбэл бага насны хүүхдүүдэд зориулсан үдийн цай, сургуулийн сүү гэх мэт хөтөлбөрүүд юм.



The Defacto Gazette

НЭГ УЛИРЛЫН ҮНЭ
30.000₮

МОНГОЛ ШУУДАН
7007-8916

ХЯТАД БА ӨМНӨД СОЛОНГОС

▶ Хүүхдүүдийн шим тэжээлийн дутагдлыг нөхөх замаар ядуурлыг бууруулах, боловсролын чанарыг сайжруулах зорилгоор Хятад улс Сургуулийн сүү хөтөлбөрийг 2000 оноос хэрэгжүүлж эхэлжээ. Үндэсний, мужийн, хотын түвшинд энэ хөтөлбөрийг хариуцсан нэгжүүд, нийлүүлэгчдийг бий болгож, гэрчилгээ олгон баталгаажуулах зэрэг олон ажил тэд зохион байгуулав. “Сургуулийн сүү” гэсэн шошго бий болгов. Таван жилийн дотор 28 муж, 60 хотын 10 мянган сургуулийн 2,4 сая сурагчдыг хамруулав. Өдөрт хоёр жижиг сав сүү уусан хүүхэд, сүү уугаагүй хүүхдээс илүү хурдан өссөн (6 сарын дотор 7,2 мм-ээр илүү), шүд нь илүү цагаан болсныг судалгаагаар тогтоов. Энэ хөтөлбөр өнөөгийн хятад залуус өндөр, эрүүл шүдтэй болоход нөлөөлсөн гэнэ ээ.

“Сургуулийн сүү” хөтөлбөр ирээдүй үеийн эрүүл мэндээс гадна, БНХАУ-ын эдийн засагт ч эерэгээр нөлөөлжээ. Сүүний чиглэлийн үйлдвэрлэл хөгжиж, үнэ цэнийн хэлхээнд (value chain) чанарын шинэчлэлт авчирчээ. Хятад улс 1999 онд 8 сая тонн сүү үйлдвэрлэж байсан бол 2002 онд 14 сая, 2017 онд 35 сая тонн

болсон жишээтэй.

Өмнөд Солонгос улс НҮБ-ын Хүүхдийн Сангийн тусламжтайгаар 1953 оноос сургуулийн хүүхдийн үдийн цай хөтөлбөр хэрэгжүүлж байна. Солонгосын дайны дараа эхлүүлсэн энэ хөтөлбөр өрхийн санхүүгийн байдлаас нь үл хамааран бага, дунд, ахлах ангийн бүх сурагчдыг бүрэн хамруулж иржээ. Мөн 1970-аад оноос “Сургуулийн сүү” хөтөлбөр нэмж эхлүүлсэн байна. Сүү хөтөлбөртэй сургуулийн сурагчид хөтөлбөр эхлээгүй сургуулийн сурагчдаас 1,5 дахин илүү уураг авч буйг *судалгаагаар* тогтоожээ. Мөн сурагчид өдөрт авах ёстой кальцийн хэрэглээнийхээ талаас илүү хувийг энэ хөтөлбөрөөр дамжуулан авч байна.

Зарим орны *судалгаануудаас* харахад бага насны хүүхдүүдсүү, сүүн бүтээгдэхүүнээс зөвхөн шаардлагатай уураг, бусад шим тэжээлийг аваад зогсохгүй, мөн сүү, сүүн бүтээгдэхүүн насан туршдаа хэрэглэх зуршилтай болж байна. Ер нь энэ хөтөлбөрийн ач тусыг олон улсад хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлж байна.

Орнууд	Эхэлсэн жил	Хөтөлбөрийн нэр	Хамрах хүрээ
Бангладеш	2013	Сургуулийн сүүг жижиг фермерүүдээс	17 дунд сургуульд
БНХАУ	2000	Үндэсний сургуулийн сүү	Орон даяар
Энэтхэг	2006	Доод Санжеевани	Гужарат муж
Монгол	2006	Үдийн хоол	Орон даяар
Непал	2003	Сургуулийн сүү	Катманду
Филиппин	1995	Дотоодын сүүгээр тэжээх	Сонгогдсон тойргуудад
Шри Ланк	2014	Сургуулийн сүү хөтөлбөр	Орон даяар
Вьетнам	2016	Үндэсний сургуулийн сүү хөтөлбөр	Орон даяар

Эх сурвалж: *Dairyasia.org*, 2017

МОНГОЛ

Монголд “Үдийн цай” хөтөлбөрийг ЕБДСургуулиудад 2006 оноос хэрэгжүүлж эхэлжээ. Харамсалтай нь энэ хөтөлбөрийг хүүхэд бүрт өгөх шим тэжээлээр биш зарцуулах төгрөгөөр хэмждэг ажээ. Нэг хүүхдэд ногдох зардлыг анх 300 төгрөг, жилийн дараа 600 төгрөгөөр хэмжих болов. 2019 оны хавар Үдийн цай хөтөлбөрийг “Үдийн хоол” болгох хуулийг УИХ баталжээ. Нийгмийн сүлжээгээр хоолны төсөв нэмэгдсэний хэрээр худалдан авах үнэ нь өсч байгаа тухай шүүмжлэл өрнөх боллоо. Улс төрчид хэдэн төгрөг зарцуулснаа л ярихаас, хичнээн калори, ямар шим тэжээл өгсөн, ямар үр дүнд хүрснээ ярих соёл Монголд тогтохгүй байна. Үдийн цай

хөтөлбөрийн үр дүнг нэгтгэн дүгнэсэн албан судалгаа олдохгүй байна. Энэ хөтөлбөр сургуулийн хүүхдүүд, ялангуяа бага орлоготой өрхийн хүүхдүүдэд суралцахад нь нэмэр болдог гэж зарим эцэг эхчүүд л хэлж байна.

Ямар ч гэсэн энэ төрлийн хөтөлбөр нь бага насны хүүхдийн хоол тэжээл, витамин дутагдлыг нөхөх зорилготой билээ. МУ-ын хүн амын хоол тэжээлийн үндэсний 5 дугаар судалгаагаар 6-11 насны хүүхдүүдийн 7 хувь нь өсөлт хоцролттой, 3 хувь нь туранхай гарчээ. Харин нийт хүүхдийн 22 хувь илүүдэл жинтэй, 6 хувь нь таргалалттай байна. ▶▶

- Энэ нөхцөлд МУ “Үдийн хоол” хөтөлбөртөө, сүүг тусгайлан оруулах нь илүү үр дүнтэй болохыг бусад орны туршлага батлаж байна. Монголд сурагчдын ердөө 5 хувь нь сургууль дээрээ сүүн бүтээгдэхүүн хэрэглэдэг ажээ. (Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай, 2018). Уг нь бид хүүхдүүддээ хангалттай сүү амархан өгч чадах юм.

Сүүний дотоодын хэрэгцээгээ хангах боломж (хувиар) (Self-sufficiency ratios)							Экспортын хувь (2013 он)
	1963	1973	1983	1993	2003	2013	
Афганистан	99.7	99.3	98.3	98.2	95.6	88.1	0.0
Бангладеш	95.2	85.5	83.5	87.2	87.9	82.4	0.0
Хятад	99.5	100.0	98.3	97.9	94.6	83.0	0.3
Энэтхэг	97.4	98.6	99.6	100.0	99.9	100.0	1.6
Индонез	58.2	36.8	26.4	55.9	40.6	34.9	3.2
Монгол	90.8	82.6	83.3	98.8	96.4	98.3	0.0
Мьянмар	48.8	87.8	95.9	89.8	87.9	94.8	0.0
Непал	100.0	100.0	97.2	98.2	97.7	98.7	0.0
Филлипин	6.0	5.0	3.9	1.1	0.6	0.6	5.1
Шри-Ланка	58.7	61.7	52.5	57.8	23.1	37.3	1.2
Тайланд	2.3	3.5	6.9	15.6	38.0	46.9	14.4
Вьетнам	99.7	99.3	98.3	98.2	95.6	88.1	0.0

Эх сурвалж: Dairyasia.org, 2017

Энэ хүснэгтээс харахад Хятад зэрэг улсуудад сүүний нийлүүлэлтээ нэмэгдүүлэхэд хүндрэлтэй бол, Монгол бүрэн боломжтой. Гэвч сүү нь байгаа ч, нийлүүлэх дэд бүтэц дутагдалтай байна. Сүү эмзэг бүтээгдэхүүн учир илүү нарийн стандарт, хяналт шаарддаг. Нийгмийн өмнө тулгарсан олон асуудлуудын суурь бол ядуурал бөгөөд үүнийг шийдэхэд ийм чухал үүрэгтэй ч, монголчуудын үл тоож буй нэгэн шийдвэр бол хүүхдийнхээ өдрийн хоолонд сүү оруулах хөтөлбөр юм.

2020.01.15

“ЭРХ ЧӨЛӨӨ”
ГУРВАЛ НОМ

Интерном номын
дэлгүүрийн бүх салбаруудаар
худалдаалагдаж байна.

+(976) 9410 9342



НИЙТЛЭЛ

Б.НАСАНБАЯР

Ph.D /Боловсрол судлал/

ЛИБЕРАЛ

— БОЛОВСРОЛ —

Учир шалтгааныг ялгаж салгах чадвар нь хүнийг бусад амьд биетээс ялгаж байдаг. Амьтад учир шалтгаанд үл захирагдах учир зөвхөн өөрийг нь өдөөсөн зүйлд хариу үйлдэл үзүүлдэг. Тэдэнд жинхэнэ бодол эсвэл эргэцүүлэл гэж байдаггүй. Харин хүмүүс, ялангуяа либерал аргаар боловсрол эзэмшсэн хүмүүс либерал байдлаар бодож, сэтгэж, ярьж зөвлөлдөх чадварт суралцсан байдаг. Зарим хүмүүс бодлогогүйгээр шууд хариу үйлдэл үзүүлдэг, энэ нь тэд оюун санаа, сэтгэх чадварыг сэргээж, учир шалтгааныг хайх, зөвлөлдөхийг сургадаг либерал сургалтын хөтөлбөрт хамрагдаж байгаагүйтэй холбоотой.

2020 онтой золгох мөчид Ерөнхийлөгчийн “тэтгэврийн зээл тэглэнэ” гэсэн дарстай хундага, УИХ-аар хууль

болон батлагдаж “чимээгүй гамшгийн харанга” дэлдлээ. 1990 оны үеэс коммунист системийн орнууд үндсэн үзэл баримтлалаасаа татгалзан ихэнх нь либерал болоход, Монгол улсын нийгэм, улс төр, эдийн засаг либералчлагдаж, 1992 оны либерал Үндсэн хуулиараа үүнийгээ хуульчилсан юм. Сонгуулиас сонгуулийн хоорондох улс төрчдийн амлалт, асар их “үнэтэй” зүйлээ “үнэгүй” хэмээн бэлэн мөнгөөр худалддаг ард түмэн яагаад ийм байдалд орж буй учир шалтгааныг олж харах нь өнөөгийн бидний хариуцлага болоод байна. Үүний шалтгаан нь монголын нийгэм, улс төр, эдийн засаг либералчлагдаад 30 жил болсон ч боловсролын салбарын бодлого, сургалтын хөтөлбөр нь либерал үзэлд суурилж жинхэнэ утгаараа хөгжөөгүйтэй шууд холбоотой юм.

ЛИБЕРАЛ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Либерал боловсролын зорилго нь ардчилсан нийгмийн идэвхтэй оролцогч, хурдтай хөгжин өөрчлөгдөж буй өнөөгийн нийгэм, тодорхойгүй ирээдүйд зохицон амьдрах чадвартай иргэнийг төлөвшүүлэх юм. Либерал боловсролын гол цөм нь либерал хөтөлбөр. Хэдийгээр оройтсон ч дахиад 30 жилийн дараа өнөөгийн түүхийг давтахгүй шийдэл бол либерал хөтөлбөрийг хөгжүүлэхэд онцгойлон анхаарах юм.

Жон Дью 1899 онд хэвлүүлсэн “Сургууль болон Нийгэм” номондоо “хөтөлбөрийн төвд суралцагч байж, хичээл түүнд зориулагдах учиртай” гэдгийг онцолсон байдаг бол Чикагогийн Их Сургуулийн боловсрол болон байгалийн шинжлэх ухааны профессор Шваб өөрийн бүтээлдээ “хөтөлбөр бол онолын шинжлэх ухаан биш ёс суртахууны практик” гэж үзсэн байна.

Либерал хөтөлбөр нь тодорхой үзэл бодлыг

тулган итгүүлж үнэмшүүлэхийн эсрэг юм. Энэ аргаар боловсрол эзэмшсэн хүмүүс хувийн үзэл бодлоо сайтар боловсруулж, түүнийгээ учир шалтгаан нь тодорхой, итгэл үнэмшил, үндэслэлээр батлан харуулж чаддаг. Мөн энэ хөтөлбөр нь хичээл агуулга сэдэвт анхаарахаас илүү суралцагчдад бие даасан байдал, эрх чөлөө хариуцлагыг олгож, ухаалаг эргэцүүлэл хийх, манлайлах чадвар эзэмших боломж олгодог. Энэ нь бусдын нөлөөнд шууд автах эсвэл зөвхөн материаллаг үзэлд хөтлөгдөхөөс сэргийлдэг гэсэн үг.

Платон “Бүгд Найрамдах” гэх бүтээлдээ учир шалтгааны хүчийг хамгийн сайнаар харуулж чадсан ба либерал хөтөлбөр бол хүүхэд, залуучуудад учир шалтгааныг ойлгох хувийн сахилга батыг бэхжүүлэх замаар “хүмүүсийн амьдрал дахь хамгийн хүчтэй зүйл нь аливаа зүйлийн учир шалтгааныг танин мэдэж, ухаарахад оршино” гэдгийг чухалчилсан байдаг. ►►

ШИЙДЭЛ

► Их дээд сургуулиудын сургалтын стандарт, мэргэжлийн хөтөлбөрийн агуулга, заах хичээлийг яам зөвшөөрөл олгож байсныг өөрчилж, 2014 онд дээд боловсролд хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг баталсан. Энэ шаардлагын дагуу хөтөлбөрөө боловсруулан тасралтгүй сайжруулж, сургуулийн захирал баталдаг болсон нь их дээд сургуулиудыг илүү бие даасан нээлттэй болгох буюу либералчлах зорилготой байсан. Мөн сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын цөм хөтөлбөр, Зөв Монгол хүүхэд, Авьяас, Ном хөтөлбөрийг сургууль, цэцэрлэг, орон нутагт, хүүхэд бүрийн давуу талд суурилан бие даасан, өөрийн шийдвэр, үйлдлийн үндэслэлийг сайтар тунгаах чадвартай, бодит байдал болон зорилгодоо төвлөрсөн хандлагатай иргэнтөлөвшүүлэх зорилготой хэрэгжүүлсэн. Гэвч улс төрийн явцуу хүрэнээс хамаараад хэрэгжилт нь үндсэндээ зогсонги байдалд хүрээд байна.

Либерал хөтөлбөрийг хэрэгжүүлэх эхний алхам бол арга зүйн хувьд суралцагч үзэх хичээлийнхээ агуулгатай урьдчилан танилцсан байх нөхцөл юм. Багш нар хичээлийн хөтөлбөрийг суралцагчдад сэдэв бүрээр нь уншиж танилцах эх сурвалж ном зүйн хамт танилцуулж, тэдний гарт хүргэх учиртай. Суралцагч өөрийн санаа бодлоо илэрхийлэх, үнэлэлт дүгнэлт хийх баримжаатай болж, багш, суралцагчийн харилцан идэвхтэй ажиллах арга зүйг нэвтрүүлснээр багш “бүхнийг мэдэгч, шийдэгч” субъект байх бус чиглүүлэгч болсноор тэднийг задлан шинжлэх арга барилд суралцах боломж олгодог. Ингэснээр суралцагчид харилцан бие биенээсээ суралцах, хөгжих нөхцөл бүрдэж багш тэдний үзэл бодлыг шаардлагатай тохиолдолд залруулан, чиглүүлнэ. Энэ арга зүйн нэг хэлбэрийг хэрэгжүүлэхэд л суралцагчдын идэвх, оролцоо, суралцах соёл, арга барилд маш олон талын эерэг дүр төрх бий болно.

Бизнесийн байгууллагууд шинээр орох ажилтандаа дараах шалгуурыг тавьж байна.



Economist intelligence unit survey (2014)

Боловсролын салбарын чанар, хөгжил бол нэг цэгт хүрэх тухай ойлголт бус, ямар нэг том аз, гайхамшиг тохиолдож нэг үйлдлээр бүхнийг шийдэх боломжгүй, тууштай хичээл чармайлт, хамтын ажиллагааны тасралтгүй үйл явц юм. Тиймээс олон нийт боловсролын салбараас богино хугацаанд их үр дүн шаардах тусам улс төрчдийн шийдэл судалгаагүй, аргацаасан, түр зуурын үйлдэлд төвлөрсөөр өдийг хүрсэн. 2020 оны сонгуульд боловсролын чанарыг байшин барилга бус боловсролын байгууллагыг улс төрөөс хараат бусаар ажиллах, либерал хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх боломж олгоно гэсэн үзэл санаа бодит төлөвлөгөөтэй, чадвартай хүний нөөцийн багтай улс төрийн намыг сонгох хэрэгтэй байна.

2020 оны 1-р сар



ДеФакто **ТОЙМ**

Ням гараг бүр VTV телевизээр 21 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл:
2020.01.12-ны дугаар

Долоо хоног бүрийн тойм, <http://jargaldefacto.com/category/12>

ТЭТГЭВРИЙН ЗЭЭЛИЙГ ТЭГЛЭСНЭЭР ЭХНИЙ ЭЭЛЖИНД БАНКУУД ХОЖИЖ БАЙНА

1-р сарын 1-ээс эхэлсэн тэтгэврийн зээлийг тэглэх асуудлаар 10 хоног орон даяар шуугилаа. Хэдий Үндэсний аюулгүй байдлын зөвлөл тэтгэврийн зээлийг тэглэнэ гэсэн шийдвэр гаргасан байсан ч түүнийг нь улсын их хурал батлах эсэхээс эцсийн шийдвэр хамаарах байсан. Гэтэл Улсын их хурлын Баасан гарагийн хуралдаанаар хуралдаанд оролцсон гишүүдийн 79.5 хувийн саналаар тэтгэврийн зээлийг тэглэхээр болчихлоо. Нэгэнт улс төрийн шийдвэр нь гарчихсан учраас энэ нь цаашид ямар үр дагавар авчрах вэ гэдгийг ярих нь дээр байх.

Зургаа хүртэл сая төгрөгийн зээлтэй иргэд зээлээ тэглүүлнэ. Тэтгэврийн зээлгүй 194 мянган иргэнд нэг сая төгрөгийн бондын эрхийн бичиг өгнө. Бондын эрхийн бичгийг 2021 оны 5-р сарын 1-ээс эхлэн гаргана гэж байгаа. Ингэхээр нэг хоёр сарын дотор зах зээл дээр 776 тэрбум төгрөг гарна гэсэн үг. Үүнээс эхний ээлжинд банкууд л хожиж байна. Банкуудын хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн эрсдэл нь байхгүй болчихож байгаа юм. Харин эдийн засагт бол үндсэн 2 сөрөг нөлөө байгаа. Төгрөг мэдээж сулрах буюу 12-р сарын 31-нд энэ мэдэгдэл хийгдээд 11 хоногийн турш долларын ханш 12 төгрөгөөр өссөн харагдаж байна лээ. Хоёрт, УИХ-ын дарга Г.Занданшатар энэ шийдвэрээс болж инфляци 1 хувиар өснө гэж яриад байгаа. Харин би бол 1 хувиар тогтохгүй гэж харж байна. Эдийн засагчид энэ шийдвэрийн сөрөг үр дагаврууд нь 4-6 сарын дараагаас мэдрэгдэж эхэлнэ гэж хэлж байгаа. Нэмж хэлэхэд зээлгүй ахмадууд жагсаал зохион байгуулсан нь зүйн хэрэг.



2017 онд Монгол улс аврал эрэн ОУВС-ийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдсан. Гэтэл тэтгэврийн зээл тэглэх их хурлын шийдвэрийн дараа ОУВС-аас “Тэтгэврийн зээлийг тэглэсэн нь ОУВС-тай тохирсон нөхцлөө зөрчиж буй хэрэг” боллоо гэж мэдэгдсэн. Монгол улс глобал эдийн засгийн хэт жижиг ч гэсэн нэг хэсгийн хувьд дүрмээрээ тоглох ёстой л доо. Энэ 776 тэрбум төгрөг нь ДНБ-ий ~2 хувьтай тэнцэнэ. ОУВС-ийн хөтөлбөрийн дагуу бол бид санхүүгийн сахилга баттай байх ёстой, татвараа өсгөх ёстой, банк санхүүгийн системээ бүрэн эрүүлжүүлнэ гэсэн үндсэн зорилтууд тавьсан ч үүнийгээ зөрчиж байна. Нэг удаагийн аврал, нэг удаагийн өр тэглэлтээр монголчуудыг ядуурлаас гаргана гэж хэзээ ч байхгүй. Энэ бол зүгээр л сонгуульд хүмүүсийн саналыг худалдаж авч байгаа хэлбэр.

ЗАРИМ ШҮҮГЧДИЙГ ТОМИЛОО

12-р сарын 30-нд Ерөнхийлөгч зарим шүүгчдийг томиллоо. Энэ удаа орон нутгийн шүүгчдийн томилгоо, шилжүүлэлт хийгдсэн байна. Гэтэл Ерөнхийлөгч 2019 оны 6-р сард Салхитын мөнгөний ордтой холбоотой 17 шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлсэн боловч одоо болтол нөхөн томилоогүйн улмаас шүүх засаглал, түүний дундаас дээд шүүхийн иргэний танхимын үйл ажиллагаа зогсчихоод байгаа.



Ерөнхийлөгчийн бүрэн эрх

- Бүх шатны шүүгчийг хуульд заасны дагуу томилно.
- Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нарыг томилох тухай саналаа Улсын Их Хуралд оруулна. Улсын Их Хурал уг саналыг татгалзсан бол өөр хүнийг санал болгоно.
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, гишүүдийг хуульд заасны дагуу томилж, чөлөөлнө. Ингэхээр шүүхийн систем 100 хувь МУ-ын Ерөнхийлөгчөөс хамааралтай харагдаж байна.

17 шүүгчийн хувьд албан тушаалаас нь түдгэлзүүлсэн гэдэг нь ажлаас нь халсан гэсэн үг биш, тэднийг шалгаж байгаа хэрэг юм. Шүүхээр гэм буруутайг нь тогтоогоогүй л бол тэр хүн гэмт хэрэгтэн биш. Тэгэхээр шалгуулсны дараа ажилдаа буцаад орж болно. Энэ төрлийн асуудлыг шалгана гэдэг бол хугацаа их авах ажил.

Ерөнхийлөгчийн зарлигаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлсэн 17 шүүгчийн нэр:

1. Б.Цолмонбаатар – Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгч
2. Э.Халиунбаяр – Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч
3. Ц.Амарсайхан – Улсын дээд шүүхийн шүүгч
4. Б.Сайханцэцэг – Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгч
5. Д.Цолмон – Улсын дээд шүүхийн шүүгч
6. Г.Цагаанцоож – Улсын дээд шүүхийн шүүгч
7. Ж.Оюунтунгалаг – Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгч

8. Д.Дэлгэрцэцэг – Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч
9. Д.Байгалмаа – Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч
10. Х.Сонинбаяр – Улсын дээд шүүхийн шүүгч, Иргэний хэргийн танхимын тэргүүн
11. П.Золзаяа – Улсын дээд шүүхийн шүүгч
12. С.Амардэлгэрз – Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгч
13. Т.Энхжаргал – Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч
14. Б.Нармандах – Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч
15. С.Төмөрбат – Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч
16. Н.Нарантуяа – Багануур дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч
17. П.Туяат – Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч

Харин дээрх 17 шүүгчийн долоогийнх нь бүрэн эрхийг Баасан гарагт сэргээж эргэн ажилдаа орох боломжтой болсон байна.

1. Х.Сонинбаяр
2. П.Золзаяа
3. Ж.Оюунтунгалаг
4. Д.Дэлгэрцэцэг
5. Д.Байгалмаа
6. Б.Нармандах
7. Т.Энхжаргал

АИ-92 ШАТАХУУНЫ ҮНИЙГ ТОГТВОРТОЙ БАЙЛГАХААР ЭРСДЛИЙН САН БАЙГУУЛНА

Лхагва гарагийн Засгийн газрын хуралдаанаар АИ-92 шатахууны үнийг тогтвортой байлгах үүднээс Эрсдлийн сан /Hedge Fund/ байгуулахаар шийдвэрлэж, үнийн өсөлтөөс урьдчилан сэргийлэх бодлогын арга хэмжээ авлаа гэж мэдэгдлээ.

Бид 100 хувь импортлогч орон учраас шатахуун бол эдийн засгийн хамгийн эмзэг сэдэв. Газрын тосны бүтээгдэхүүний үнэ нь гол түүхий эдээсээ буюу газрын тосны үнээс хамааралтай. Хоёр үнэ хоёулаа АНУ-ын доллараар илэрхийлэгддэг. Олон улсын зах зээл дээр түүхий газрын тосыг хамгийн том хоёр зах зээл буюу Европын (Брентийн) ба АНУ-ын (WTI or West Texas Intermediate) үнийг хамгийн түгээмэл хэрэглэдэг. Хоёр үнэ маш олон хүчин зүйлээс хамаарч, үргэлж өөрчлөгдөж байдаг. Томоор нь багцалбал АНУ ба ОПЕК-ийн (газрын тос экспортлогч орнуудын холбоо) харилцаа, мөн Саудын Араб, ОХУ, БНХАУ болон тэдгээрийн харилцаа, холбооны асуудлууд юм.



Монголын төр засаг өргөн хэрэглээний олон барааны үнийг тогтоож ард иргэдээ “халамжилдаг”. Гэтэл энэ үйлдэл нь эцсийн дүндээ тус биш ус буюу “баавгайн үйлчилгээ” болдог. Шатахууны үнийг одоог хүртэл шатахууны онцгой албан татварын (ОАТ) түвшинг өөрчлөн зохицуулж ирлээ. Шатахууны үнийн дөрөвний нэгээс, заримдаа хагасыг нь хүртэл эзэлдэг ОАТ-ыг хилийн буюу ам.долларын үнэ өсөхөөр бууруулж, бууруулахаар өсгөж ирлээ. Гэхдээ энэ татварыг хилийн үнийн тодорхой хувиар тогтоохын оронд шууд тонн тутамд төгрөгөөр тогтоодог учир, төгрөг чангарвал шатахууны үнэ буурдаггүй.

Уг нь аливаа барааны үнийг зах зээл тогтоосон нь урт хугацаандаа хэрэглэгчдэд илүү ашигтай, урьдчилан таахад харьцангуй амархан, хүлээлтийн инфляцийг бууруулна. Зөвхөн зах зээлийн бодит үнэ л хэрэглэгчдэд үнэн мэдээлэл өгөх бөгөөд үнэ юунаас хамаарч буйг хэрэглэгч ойлгосны дараа ойрын болон холын үйлдлээ бодитой төлөвлөж чадна. Түлш шатахууны үнийг төр биш, зах зээл тогтоовол импортлогч компаниудын хооронд амьд өрсөлдөөнийг өдөөж, зардлаа хэмнэх замаар шатахууны үнээ бууруулна.

Аливаа эрсдлээс хамгаалах хүн төрөлхтний бодож олсон арга бол даатгал. Барааны үнийн савалгаанаас хамгаалах тэр даатгалыг гадаад худалдаанд хэджинг (hedging) гэдэг. Хэджинг нь тодорхой үнийн түвшин дээр тохиролцоо хийнэ. Тохирсон хугацаа болохоор, үнэ өөрчлөгдсөн ч, анх тохирсон үнээрээ л бараа авна, эсвэл зарна. Энэ үйлчилгээг авахын тулд тодорхой төлбөр (premium) эхлээд төлнө. Даатгуулсан талд үнэ өсчихвөл ашигтай, үнэ буурчихвал алдагдалтай. Даатгасан талд эсрэгээрээ.

Худалдааны эргэлт маш том, олон улсын түүхий эдийн трэйдэр компаниуд Хэджинг үргэлж ашигладаг. Гэхдээ үнэ өөр болсон ч авах эсэхээ сонгох сонголттой (option) даатгал ч бий. Үнэ буурчихвал, буурсан үнээр нь авна гэвэл дахиад л илүү төлбөртэй. Гэхдээ буурсан үнээр авч, өрсөлдөгчидтэйгээ адилхан үнээр зарахгүй бол зах зээлээ алдана. Хэджинг/опцион өндөр зардалтай учир олон улсын трэйдинг компаниудаар дамжуулахаас өөр эдүгээ сонголт алга байна. Төр засаг хэрэв үнэ хянах бодлогоо үргэлжлүүлнэ гэвэл ОАТ-ын хөрөнгөөр сан байгуулж, тэндээс энэ хэджинг хийж болох юм.

Шатахуунаар хараат бус болох, үйлдвэр барих тухай монголчууд олон жил ярьсан нь Дорнодод газрын тос илрүүлснээс хойш бүр идэвхижсэн. 2015 оны 5-р сард

БНЭУ-ын Ерөнхий сайд Нарендра Модиг Монголд айлчлав. Монголын эдийн засгийн хөгжилд зориулж Энэтхэг 1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээл олгох болов. Энэ зээлээр газрын тос боловсруулах үйлдвэр байгуулахаар МУ-ын Засгийн газар 2017 оны 2-р сард шийдэв. Шатахууныг хэрэглэгчид ойртуулах, бусад нөхцөл байдлыг тооцоод үйлдвэрийг Дорноговийн Сайншандаас зүүн хойш 18 км зайд, Алтанширээ сумын нутагт барих болов. Энэ үйлдвэр жилд шингэрүүлсэн шатдаг хий 43, автобензин 340, дизель 824, онгоцны түлш 80, зуухны түлш 47 мянган тонн буюу нийт 1.35 сая тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэж МУ-ын өнөөгийн хэрэгцээг хангах юм. Түүхий тосоо Дорнод аймгийн Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайгаас татах ажээ.

Энэ төслийг хариуцсан төрийн өмчит газрын тос боловсруулах үйлдвэрийн газрыг (ГТБУ) 2017 оны 4-р сард (www.mongolrefinery.mn) байгуулав. Мөн оны 8-р сард үйлдвэрийн нарийвчилсан ТЭЗҮ боловсруулахаар Энэтхэгийн олон жилийн туршлагатай “Инженерс Индия Лимитэд” (www.engineersindia.com) компанийг зөвлөхөөр шалгаруулжээ. Дээр нь хөндлөнгийн хяналт тавиулахаар Италийн “Кинетикс Технолож” компанийг оруулж, ажлаа эхлүүлэв. 2018 оны 11-р сард нарийвчилсан ТЭЗҮ дуусч УУХҮЯ-ны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр батлуулжээ. 2019 оны 5-р сараас инженерийн зураг төслөө боловсруулж эхлэв.

2019 оны 11-р сарын байдлаар Монголын Хөгжлийн банкны 246 тэрбум төгрөгийн зээлээр Сайншандаас 17.5 км хүнд даацын авто зам, 27 км урт төмөр зам, 110 квт-н цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцуудыг барьж үйлдвэрийн гаднах дэд бүтцийг байгуулж, үйлдвэр барих 150 га талбайг тэгшлэх, хашаа барих ажлыг эхлүүлжээ. Мөн Сайншандад 550 айлын, ажилчдын хотхон барьж байна. Ирэх хавар 42 км урт усны хоолой татах бэлтгэлийг хангаж байна. Энэ аж үйлдвэрийн томоохон цогцолборт технологийн байгууламжууд, олон том агуулах сав, түүхий тос тээвэрлэх, дамжуулах байгууламжаас гадна өөрийн цахилгаан станц багтаж байна.

Одоогоор, яаралтай шийдэх гол ажил бол түүхий тосоо 550 км-ийн холоос хэрхэн тээвэрлэх асуудал. Төмөр зам барих, эсвэл дамжуулах хоолой тавих сонголтын дунд төр засгийн түвшинд санал хуваагджээ.

GOOGLE STORE



APP STORE



Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв
Тоймын бүрэн эхийг jargaldefacto.com вебсайтаас үзэх боломжтой.

Та “Дефакто Газет” цахим сонинг тогтмол хүлээн авахыг хүсвэл
www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ

Ерөнхий эрхлэгч:
Дамбадаржаагийн Жаргалсайхан

Ерөнхий Редактор:
Ганбаатарын Жавзмаа

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Отгонсүрэнгийн Билгүүн
Адъяагийн Тунгалаг

ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com
☎ +976 94109342
🌐 www.defacto.mn